



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/322

Булган сум


Орос хэлний багшийн байрны
түрээсийн зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны яам болон Оросын Холбооны Улсын төсвийн ерөнхий боловсролын байгууллага Е.Д.Стасовагийн нэрэмжит “Интердом” олон улсын боловсролын төв хоорондын гэрээгээр Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд ажиллах Орос хэлний багшийн байрны түрээсийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Байрны түрээсийн зардалд шаардагдах 4,200,000 (дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийг “Шинэ Багш” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ